



У. Заяахүү
Д. Батбаяр IV/1084

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2025 он 04 сар 01 өдөр

Дугаар 1/95-А0960283-ДАА-2025/06-7-ШГА-17

Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илрэлзээ. Үүнд:

“Элчит ган” ХХК-ийн гүйцэтгэсэн Дархан-Уул аймаг дахь салбар Анаагаах ухааны сургуулийн барилгын өргөтгөл “Спорт заалны барилга”-ын ажлын 70,819,505.00 төгрөгийн төсөвт өртөгтэй дээвэр, 81,273,920.00 төгрөгийн төсөвт өртөгтэй шал, ажил гүйцэтгэх гэрээнд заасан чанарын баталгаат хугацаанд дээврээс ус гоожсон, шал завсар гарч хөндийрсэн байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д “Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулна”, Техник хяналтын талаар захиалагч, гүйцэтгэгчийн хооронд хийсэн гэрээний 2.8-д “Чанаргүй буюу дутуу гүйцэтгэсэн зөрчил, дутагдалтай барилгын ажлын талаар дүгнэлт гаргах, тогтоосон хугацаанд засуулах, учирсан хохирлыг арилгуулах арга хэмжээг авах”, 3.5-д “Буруу буюу дутуу ажлыг тогтоосон хугацаанд нь гүйцээлгэж, ажлын явцад илэрсэн дутагдал, зөрчил, доголдлыг шуурхай арилгах”, захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний 6.3, гэрээний ерөнхий нөхцөлийн 6.14-т “Чанарын баталгаат хугацаа 3 жил байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ**:

- Шаардлага хангаагүй 152,093,425.00 /Нэг зуун тавин хоёр сая ерэн гурван мянга дөрвөн зуун хорин таван/ төгрөгийн дээрх ажлыг гүйцэтгүүлж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ДХББЗГ-ын дарга Д.Батбаяр, ахлах инженер У.Заяахүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Х.СУВДМАА

АУДИТОР

Э.ОДГЭРЭЛ

БАТАЛГААЖУУЛСАН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Щ.МӨНХБАЯР 4525040293

